

## **МОНГОЛ УЛС БА ОХУ-ЫН ХИЛ ОРЧИМ, БҮС НУТАГ, СУБЪЕКТУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГА**

*С.Дамдинсүрэн\**

Монгол, Оросын олон зууны түүхэн харилцаанд хил орчим, бүс нутгууд, субъект хоорондын уламжлалт хэлхээ холбоо, хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэж ирсэн, эдүгээ ч, цаашдаа ч улам өсөн нэмэгдэх ирээдүйтэй юм. Энэ нь гүн гүнзгий бодит учир шалтгаантай. Тухайлбал:

- Монгол Улс, ОХУ-ын 3500-гаад км үргэлжилсэн нийтлэг хилийн өргөн уудам нутгийг бүхэлд нь хамран оршдог Сибирь нутаг, түүний субъектууд нь Монголтой геоэкологи, геоэдийн засаг, геополитикийн харилцан хамаарал ихтэй.

- Олон зууны турш нүүдлийн соёл иргэншлийг хамтдаа бүтээсэн угсаа гарал, хэл, соёл, ёс заншил, амьдрал ахуй ойролцоо ард түмнүүд зэрэгцэн оршиж үнэт зүйлээ хуваалцаж байдаг сайхан уламжлалтай.

- Хоёр талын янз бүрийн бүс нутгийн онцлогийг тусгасан субъект хоорондын шууд харилцааны үндэс суурь болох бие биенээ нөхөн сэлбэх нөөц баялаг, өргөн боломжтой, тэдгээрийг нээн илрүүлж зах зээлийн харилцааны шинэ нөхцөлд хөгжлийн хүчин зүйл болгох нийтлэг сонирхолтой.

- Шинжлэх ухаан, технологи, мэдээлэл, эрчим хүч, зам харилцааны эх үүсвэр тавигдсан хэтийн төлөв бүхий дэд бүтцийн улам өргөжин тэлэх холбоотой.

- Олон улсын талбарт глобалчлалын ерөнхий чиг хандлага, Ази-Номхон далайн бүс нутаг, түүний салбар бүсүүд, тухайлбал, Зүүн Хойт Азийн эдийн засгийн интеграцид хамтран оролцох нийтлэг эрмэлзэлтэй.

- Хоёр улс зах зээлийн харилцаанд нийцсэн нээлттэй бодлого явуулж төвлөрлийг сааруулах, бүс нутгийн санаачилга, бие даасан байдлыг дэмжих чиглэлээр хил орчим, бүс нутаг, субъектуудын шууд харилцааны улс төр, эрх зүйн таатай орчинг бүрдүүлж буй зэргийг онцлон дурдаж болох юм.

Бүс нутгийн харилцаа бол улс төрийн гэхээсээ эдийн засаг, соёл иргэншлийн үнэт зүйлд илүү тулгуурласан, бие биеэс нь салгаж болшгүй бодит шүтэлцээ, харилцан хамаарлыг шингээн илэрхийлж, хүмүүнлэгийн хүчин зүйлд шууд чиглэсэн тасралтгүй үргэлжилсэн хөдөлгөөнт чанарыг агуулж байдгаараа хөрш орнуудын хөгжлийн чухал зүй тогтолг үйл явц мөн болно. Энэхүү бодит зүй тогтлыг танин мэдэж, мөн чанарыг нь нээхийн

\*С.Дамдинсүрэн - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

хэрээр, шилж сонгодоггүй, салгаж болдоггүй хөршүүдийн хамтын ажиллагааг зах зээлийн харилцааны шинэ нөхцөлд нийцүүлэн бие биедээ оршихуй, хөгжихүйн хүчин зүйл болж байх бодит агуулгын түвшинд нь хүртэл сэргээн идэвхжүүлэх шаардлага тавигдсан нь тодорхой.

1990 оны эхнээс Монгол, Оросын харилцаа хуучин тогтолцооны задралын давалгаанд өртөн ерөнхийдөө үлэмж суларч саарсан хэдий ч бүс нутаг, субъектуудын уламжлалт шууд харилцааг хадгалж сэргээн хөгжүүлэх эрмэлзэл, чармайлт тасалдаагүй билээ. ХХ зууны сүүлийн арваад жил бол хоёр орны харилцааны агуулга, хэлбэр, түүний дотор бүс нутаг, субъект хоорондын хамтын ажиллагааны шинж чанар, арга, механизмыг бүх талаар шинэчлэх үе байсан гэж болох юм. 1991-1993 онуудад Монгол, Оросын удирдлагын дээд түвшинд хийсэн уулзалт хэлэлцээрүүд, ялангуяа 1993 онд Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат, ОХУ-ын Ерөнхийлөгч Б.Ельцин нарын гарын үсэг зурсан “Монгол Улс, Оросын Холбооны Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ” нь хоёр улсын харилцааны олон жил хэвшин тогтсон хуучин загварыг халж шинэчлэгдэн хөгжих эрх зүйн үндсийг тавьсан юм. Тухайлбал, хоёр улс “Өөр хоорондын харилцаандаа бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг хүндэтгэх, адилхан бүрэн эрхтэй байх, хүч үл хэрэглэх буюу хүчээр сүрдүүлэхгүй байх, хилийн халдашгүй дархан байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, дотоод хэрэгт үл оролцох, хүний эрх болон үндсэн эрх чөлөө, улс түмний тэгш эрх, хувь заяагаа өөрсдөө шийдвэрлэх эрхийг хүндэтгэх, хүлээсэн үүргээ ёсчлон биелүүлэх, сайн хөрш түншийн ёсоор хамтран ажиллах зарчмуудыг удирдлага болгоно” гэж заасан байна. /Засгийн Газрын мэдээ. 1993 он. 2 дугаар сар. №5/

Энэ нь хоёр орны хил орчим, бүс нутаг, субъектын хоорондын харилцааг шинэчлэх, түүний эрх зүй, механизмыг боловсронгуй болгох тулгуур үндэс болсон юм.

Ерээд оны эхэн үеийн гэрээ, хэлэлцээрүүдийн нэг чухал үр дүн бол худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах Монгол, Оросын засгийн газар хоорондын комисс байгуулсан явдал бөгөөд чухам энэ комисс хоёр орны бүс нутаг, хил орчим, субъектуудын хамтын ажиллагааг зохион байгуулж, төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

Тус комиссын 1992 онд Улаанбаатарт болсон анхдугаар хуралдаанаар хил орчмын болон аймаг, мужууд, үйлдвэр компани, пүүс хоршоо, аж ахуйн нэгжүүдийн хоорондын харилцааг цаашид өргөжүүлэхэд бүх талын туслалцаа үзүүлэхээр тохиролцсон бол 1993 онд Красноярскт болсон II хуралдаан салбар, субъектуудын хамтын ажиллагааг өргөтгөх, шинэ хэлбэрүүдийг бий болгох шийдвэр гаргажээ.

II хуралдааны үеэр хоёр талын ажил хэрэгч хүмүүсийн анхны уулзалтыг зохион байгуулсан нь тийм хамтын ажиллагааны үр ашигтай хэлбэр болохоо харуулж бүс нутгуудыг хамран тогтмолжиж байна. 1995 онд болсон тус комиссын III хуралдаан хоёр орны харилцааны шинэ загварыг аж ахуйн амьдралын бүх түвшинд эрчимтэй хамтын ажиллагаа явуулах замаар боловсронгуй болгон сайжруулах асуудал хэлэлцэж санал солилцсон нь бүс нутаг, субъектуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд ихээхэн түлхэц өгсөн юм. Энэ мэтээр засгийн газар хоорондын комиссын дараа дараагийн хуралдаанууд хил орчим, бүс нутаг, субъектуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх байнга нөлөөлөх оновчтой механизмыг бүрдүүлэхэд ихээхэн анхаарч иржээ. Засгийн газар хоорондын комиссын 1996 оны 2 дугаар сард хуралдсан IV хуралдааны шийдвэрийн дагуу Монгол, Оросын бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны Дэд Комисс байгуулагдсан байна. Харин 1997 оны 1 дүгээр сард хуралдсан Засгийн газар хоорондын комиссын V хуралдааны шийдвэрээр бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны Дэд комиссын анхдугаар хуралдаан мөн оны 6 дугаар сард Улаан-Үд хотноо болж худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах Засгийн газар хоорондын комиссын бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны программын тухай, Монголын аймгууд, Оросын Холбооны субъектуудын хооронд бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны санхүү, банкны механизм зэрэг асуудлуудыг хэлэлцжээ. Дүрмийн төслийг хэлэлцэн сайшааж, түүнийг худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах Засгийн газар хоорондын комисст батлуулахаар танилцуулах нь зүйтэй гэж үзсэн байна. Программын төслийг хэлэлцэхдээ хамтын ажиллагааны зорилтуудыг шийдвэрлэх төлбөр тооцооны мөнгөн ба барааны хэлбэрийн тухай, санхүүгийн хэрэгслийг төвлөрүүлэх, материал-техникийн болон бусад нөөцийг нэгтгэх, аж ахуйн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, тус тусын санхүүгийн дотоод эх үүсвэрийг дайчлахаас гадна гуравдахь орны зээлийг хамтран татан оролцуулах зэрэг эдийн засгийн зохицуулалтын янз бүрийн аргыг хэрэглэхийг чухалчлаад хоршоололсон хамтын ажиллагаа, хамтарсан үйлдвэр байгуулах тухай шинэ зүйл нэмж Монголын аймгууд ба Оросын субъектуудын удирдлагад тараан хэлэлцүүлэн Дэд комиссын үндэсний хэсгүүдэд зохих боловсруулалт хийсний дараа түүнийг худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах Засгийн газар хоорондын Комисст оруулахаар тогтжээ. Монголын аймгууд ба Оросын Холбооны субъектуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар тус хуралдаан нэлээд олон талаас нь хэлэлцэж шууд харилцаа, худалдаа-эдийн засгийн харилцааны практик асуудлуудыг

шийдвэрлэхийн тулд хоёр талын ажлын айчлалууд хийх, Протокол байгуулах, аль алиныхаа нутаг дэвсгэрт, ялангуяа, мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах, эрчим хүчний ба барилгын цогцолборууд, үйлдвэрлэлийн дэд бүтцийн салбаруудын чиглэлээр хамтарсан үйлдвэрүүд байгуулах замаар харилцан шууд хөрөнгө оруулалтын хэлбэрүүдийг ашиглахыг заагаад Монголоос амьд мал, мал аж ахуйн бүтээгдэхүүн нийлүүлэх хэмжээг өргөтгөх, энэ зорилгоор мал эмнэлгийн хяналтын шуурхай байдлыг хангах, санхүүжүүлэх асуудлыг Оросын Холбооны холбогдох байгууллагад тавих нь зохистой гэж үзжээ.

Дэд комиссын анхдугаар хуралдаанаас хил орчмын хамтын ажиллагаанд оролцогч бүс нутгуудад консулын салбарын сүлжээг өргөтгөх, худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны байнгын оролцогчдод зориулан 1-2 жилийн хугацаатай олон удаагийн визийн систем тогтоох талаар арга хэмжээ авах зэрэг асуудлыг Монгол, Оросын дипломат албадад тавьж шийдвэрлүүлэх, мөн хилийн нэвтрэх боомтуудын тухай болон Монгол-Оросын хилийн харилцааг хялбарчилах тухай, иргэд харилцан зорчих нөхцлийн тухай, хил орчим бүсүүдийн ойн түймрээс сээрэмжлэх, түүний хор уршгийг арилгах талаар ойрын хугацаанд засгийн газрын хооронд хэлэлцээр хийх асуудлыг Монгол Улсын Гадаад Харилцааны Яам, ОХУ-ын Гадаад Хэргийн Яаманд санал болгохоор тохиролцжээ. Бас Монголын эскпортын бараа нийлүүлэлтэд тааламжтай журам тогтоож өгөхийг Оросын Холбооны Засгийн газарт санал болгохоор шийдвэрлэсэн байна. Программ дотор орсон төслүүдийг бараа солилцооны ажиллагаагаар гүйцэтгэх тул түүнд шаардагдах санхүүгийн хэрэгслийг арилжааны банкуудын, түүний дотор гурав дахь орны банкуудын зээлийг татан оролцуулах замаар хангаж байх, төслүүдийг санхүүжүүлэхдээ Монголын талаас: Хөрөнгө оруулалт өөрчлөн байгуулалтын банк, Худалдаа хөгжлийн банк, Оросын талаас: Промстройбанк, Инком банк, Сбербанк РФ, Биком банк оролцож хамтран ажиллахаар төлөвлөжээ. Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагаанд оролцогч банкуудад төлбөр тооцоондоо үндэсний валютаа хэрэглэх зөвшөөрөл олгох асуудлыг Монгол Улсын ба Оросын Холбооны Төв банкуудад хүсэлт болгохоор шийдвэрлэсэн байна.

Ийнхүү Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны Дэд комиссын анхдугаар хуралдаан нь тус комиссын ажлын ерөнхий чиг хандлага, эрх зүйн үндэс, хэм хэмжээ, программын зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга механизмыг тодорхойлох томоохон алхам хийжээ.

1998 онд хуралдсан хоёр улсын Засгийн газар хоорондын комиссын VI хуралдаанаас бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны Дэд комисс байгуулсныг батлах шийдвэр гаргаж, түүнийг худалдаа-

эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын ажлын байнгын байгууллага байхаар тогтоосон байна. Монголын ба Оросын гэсэн хоёр хэсгээс бүрдэх Дэд комисс нь тус бүрдээ даргатай байх бөгөөд бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны талаар хөтөлбөр, төсөл боловсруулж Засгийн газар хоорондын комисст санал оруулах, бас бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны үр дүнг хэлэлцэж түүнийг цаашид хөгжүүлэн өргөжүүлэх, боловсронгуй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлж байх үүрэг хүлээлгэж Дэд комиссын дүрмийг баталж, үйл ажиллагааных нь программыг гүйцээн болосвруулах, батлах ажлыг түргэтгэхийг заажээ. 2000 оны 11 дүгээр сарын дундуур Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн урилгаар ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Монголд айлчлах үеэр Монгол Улсын орон нутгийн засаг захиргаад, ОХУ-ын субъектуудын гүйцэтгэх засаглалын байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааны зарчмуудын тухай Хэлэлцээрт гарын үсэг зурсан Монгол, Оросын хил орчим, бүс нутаг, субъектуудын харилцаа, хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бэхжүүлэхэд их ач холбогдолтой болов.

Энэхүү хэлэлцээрт: “ОХУ-ын субъектуудын гүйцэтгэх засаглалын байгууллага” гэж ОХУ-ын Бүгд найрамдах улс, хязгаар, муж, холбооны хэмжээний хот, автономит муж, автономит тойргийн гүйцэтгэх засаглалын дээд байгууллыг, “Монгол Улсын орон нутгийн засаг захиргаа” гэж Монгол Улсын аймаг, нийслэлийн засаг захиргааг хэлнэ гэж заагаад ОХУ-ын хил орчмын Алтай, Буриад, Тувагийн Бүгд найрамдах улсууд, Эрхүү, Чита мужууд, Монгол Улсын хил орчмын Дорнод, Хэнтий, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Завхан, Увс, Баян-Өлгий аймгуудын хоорондын бүх талын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхийг онцолжээ. Хоёр талын гүйцэтгэх засаглалын байгууллагууд өөрсдийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар хамтран ажиллах талаар тохиролцож олон улсын гэрээнд үл тооцогдох хэлэлцээрт хуулиар тогтоосон журмын дагуу гарын үсэг зурахыг зөвшөөрч, гадаад эдийн засгийн харилцааг бие даан явуулах эрхийг нь нэмэгдүүлэхээр тогтоохын хамт, харин гадаад бодлого, батлан хамгаалах, улсын хил, агаарын тээврийн харилцааны салбарт хамаарах асуудал, хоёр улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хөндөж буй асуудлыг шийдвэрлэх эрхгүй, түүнчлэн хоёр улс, тэдгээрийн Засгийн газар, төв яам, агентлагуудын хооронд байгуулсан хэлэлцээрүүдэд өөрчлөлт оруулах буюу тэдгээрийн талаар тусгай санал гаргах эрхгүй болохыг зааж өгсөн нь хил орчим, бүс нутгууд, субъектуудын эрх зүйн хэм хэмжээг боловсронгуй болгон бэхжүүлэх чухал үндэслэл болов. Ялангуяа гадаад эдийн засгийн харилцааг бие даан явуулах эрхийг нэмэгдүүлэх заалт

нь субъект хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэн, бие даасан санаачлагыг дэмжсэн онцгой ач холбогдолтой шийдвэр юм.

Худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн салбарт хамтран ажиллах Монгол, Оросын засгийн газар хоорондын комиссын Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны Дэд комиссын II хуралдаан 2001 оны 6 дугаар сарын 19-20-нд Улаанбаатар хотноо болж Дэд комиссын анхдугаар хурадааны шийдвэрийн биелэлтийн тухай, худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах Монгол, Оросын засгийн газар хоорондын комиссын VIII хуралдааны шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Дэд комиссын зорилтын тухай, Бүс хоорондын хамтын ажиллагааны тулгамдсан асуудлуудын тухай дэлгэрэнгүй хэлэлцэж нэлээд тодорхой санал, зөвлөмжүүд дэвшүүлсэн байна.

Дэд комиссын анхдугаар хуралдааны шийдвэр зөвлөмжийн талаар үндэсний хэсгийн удирдлагын мэдээлэлд тодрохой ажлууд хийж гүйцэтгэснийг дурдахын хамт мал эмнэлгийн хяналтын бүс нутгийн байгууллагуудын бүрэн эрхийн тухай үндэсний валютын харилцах данс нээх, Буриадын Хөдөө аж ахуйн яамнаас “Монреимпекс” компанид төлөх өрийн асуудлыг шийдвэрлэх зэрэг хэд хэдэн зүйл биелэгдээгүй тул тэдгээрийг холбогдох байгууллагад даалган гүйцэтгүүлэхээр тогтжээ.

Хоёрдох асуудлын талаар Дэд комиссын үндэсний хэсгүүд хэлэлцэн зохих шийдвэр гарган ажилласныг хуралдаан тэмдэглээд Монголын аймгууд, Оросын Холбооны субъектуудын хооронд хүмүүнлэгийн болон бусад хэлхээ холбоог хөгжүүлэх талаар Дэд комисс, түүний үндэсний хэсгүүдийн үйл ажил, зохицуулагч үүргийг идэвхжүүлэх нь чухал, шаардлагатай бол Дэд комиссын хүрээнд Монголын засаг-захиргааны байгууллагууд ба Оросын Холбооны субъектуудын гүйцэтгэх засгийн байгууллагуудын түвшинд хамтын ажиллагааг өргөтгөх талаар ажлын хэсгүүд байгуулж болно гэж үзжээ. Харилцан ашигтай эдийн засгийн төслүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхийг сонирхогч бүс нутгууд ба аж ахуйн бүтцүүдийн үйл ажиллагааг зохицуулах төвүүдийг байгуулах асуудал боловсруулах санал дэвшигдэв. Хуралдаан Монгол, Оросын хил дээр автомашин нэвтрүүлэх боомтуудыг байгуулах асуудалд онцлон анхаарч Алтанбулаг-Хиагт, Цагааннуур-Ташант, Арсуурь-Цагаантолгой, Тэс-Шарсуурь, Боршоо-Хандгайт-ын нэвтрүүлэх боомтуудыг байгуулж төвхнүүлэн ажиллуулах нь хоёр орны бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтойг тэмдэглээд автомашины нэвтрэх олон улсын Хиагтын боомтыг 2001 оны 7 дугаар сард, Алтанбулагийн боомтыг 2002 оны 3 дугаар сард багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байгаа тухай мэдээлэл хийжээ. Энэ асуудалтай холбогдуулан Монголын тал ОХУ-ын эрчим

хүчний зохих байгууллагуудад хандаж Цагааннуур, Тэс, Арцсуурь, Бага-Илэнх, Ульханмайхан хүртэл 30 км орчим урт цахилгаан дамжуулах шугам байгуулж өгөхийг хүсэлт болгожээ.

Монгол Улс, ОХУ-ын хооронд хоёр талын консулын үйлчилгээний талаар хийгдэх зөвшилцөл болон Кызылд Монголын Ерөнхий консулын газар байгуулахаар шийдвэрлэснийг тэмдэглээд Монголын баруун аймгуудын иргэдийн консулын шуурхай үйлчилгээг боловсронгуй болгох, мөн гаалийн статистик мэдээллийн арга зүй, журмын талаар хэлэлцэх материалуудыг бэлтгэж Дэд комиссын дараагийн ээлжит хуралдаанд оруулахад тохиролцжээ.

Байгаль ба хүрээлэн буй орчны салбарт хамтран ажиллах, Монгол-Оросын хилийн районд гал түймрээс хамтран хамгаалах тухай хэлэлцээрийг түргэтгэх, Орост Монголын аврагчдын мэргэжил дээшлүүлэх, Монголд байгаль, хүрээлэн буй орчны талаар олон улсын шинжилгээ судалгааны төв байгуулах Монголын талын санал, Монгол, Оросын хил дээр ажиллаж буй Монголын гаальчдыг Орост сургах гэх мэт олон асуудлыг хөндөн ярилцжээ.

Хоёр улсын хилийн районд малын хулгайтай тэмцэх, бэлчээрээр улсын хилийн давсан малыг эрж олох, буцаан өгөх талаар ажиллах хамтарсан комиссын тухай Засгийн газрын хоорондын хэлэлцээрийн биелэлтийн явцыг хэлэлцэн, энэ талаар хамтарсан комиссын ажилд дэмжлэг үзүүлэхийг хил залгаа Оросын Холбооны Бүгд найрамдах улсууд, муж, тойргууд, Монголын аймгуудын засаг захиргааны байгууллагууд, Монголын Цагдаагийн Ерөнхий газар, Хилийн цэргийн удирдах газар, Оросын Холбооны хилийн албанд зөвлөмж болгохын хамт комиссын ажилд шаардагдах хөрөнгийг хил орчмын Монголын засаг захиргааны нэгжүүд ба Оросын Холбооны субъектуудын төсвөөс гаргах асуудлыг зохих журмын дагуу авч үзэхийг бас зөвлөсөн юм.

Монгол Улс ба ОХУ-ын бүс нутгууд ба хил орчмын худалдаа, эдийн засгийн харилцаа идэвхжиж байгаатай холбогдуулан эрх зүйн зохицуулалтын механизмыг боловсронгуй болгох түүний дотор хил орчмын худалдааг зохион байгуулах, гаалийн болон визийн таатай журам тогтоох нь чухлыг нотлов.

II хуралдааны хэлэлцсэн 3 дахь зүйл бол бүс нутаг, хил орчмын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тулгамдсан асуудлуудын тухай байв. “Мянганы зам” бүтээн байгуулалтын Монголын төслийг хэрэгжүүлэхэд Оросын бүс нутгуудыг оролцуулах тухай Оросын талын саналыг автозам байгуулалтын явц ба хугацааг түргэтгэх, хоёр орны хөдөлмөрийн, материалын болон санхүүгийн нөөцийн ашиглалтын үр өгөөжийг дээшлүүлэх болно гэж дэмжсэн юм.

Монгол Улс ба ОХУ-ын бүс нутгийн хамтын ажиллагааны нэн чухал асуудлын нэг бол Монголын мал аж ахуйн бүтээгдэхүүнийг Орост, юуны өмнө Сибирь, Байгалийн хавийн бүсүүдэд гаргах экспортыг нэмэгдүүлэх явдал гэж үзээд худалдаанаас мал амьтны эрүүл мэндийг хангах, малыг эрүүлжүүлэх, мал эмнэлэг, ариун цэврийн хяналтыг хангах үндсэн дээр мах, амьд малын ОХУ-д нийлүүлэх хэмжээг нэмэгдүүлэх тухайд санал нийлэхийн хамт амьд мал нийлүүлэх асуудлыг гагцхүү Монголын засгийн газрын шийдвэрээр зохицуулдгийг тэмдэглэв. Мал аж ахуйн түүхий эд, үр тариа, төмс боловсруулах, тэжээл бэлтгэх талаар хамтарсан үйлдвэрийн газрууд байгуулах нь зохистой гэдгийг хуралдан анхаарч, энэ талаар санал бэлтгэхийг ОХУ-ын хил орчмын субъектууд, Монголын хил орчмын аймгуудад зөвлөмж болгосон юм.

Худалдаан дээр Монголын тал ОХУ-ын мал эмнэлгийн албанд хандаж Монголын мал аж ахуйн түүхий эдийг ОХУ-ын нутгаар дамжуулан өнгөрөөх зөвшөөрөл олгохыг хүссэн байна. Монголын тал бас Дорнод аймгийн Адуунчулууны нүүрсний уурхайгаас ОХУ-ын субъектуудад нүүрс экспортлох бололцоотойг батлан мэдээлэв.

Хуралдаан ОХУ-ын субъектуудын сонирхогч байгууллагуудад хандаж хамтран ажиллах талаар нэлээд тодорхой санал, санаачлагуудыг дэвшүүлэн тавьжээ. Үүнд: Дарханы төмөрлөгийн комбинат, ваар эдлэлийн үйлдвэр, Хөтөлийн цемент, шохойн заводын төслийн хүчин чадлыг хамтран эзэмших, Сэлэнгэ /үр ба ХАА-н техникийн сэлбэг/, Хөвсгөл /аж үйлдвэрийн ба хүнсний бараа, нефть бүтээгдэхүүн/, Завхан /нефть бүтээгдэхүүн/, Увс /хүнсний бараа/ аймгуудад бөөний ба жижиглэн худалдааны хамтарсан төвүүд байгуулах, дэд бүтцийн салбарт: Сэлэнгэ аймгийн “Улаан Овоо”-гийн нүүрсний сав газрыг хамтран эзэмших, дулааны эрчим хүчний цогцолборуудыг сэргээн засварлах, Улаан-Үдэд Монголын жуулчны байгууллагын төлөөлөгчийн газар нээх, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан-техникийн салбарт хамтран ажиллах, тухайлбал, оюутан, багш, эмч нар солилцох, Урал, Новосибирск, Эрхүүгийн анагаах ухааны дээд сургуулиудад мэргэжил дээшлүүлэх, Ховдод Оросын дунд сургууль байгуулах, Монголын Сэлэнгэ, Хөвсгөл, Завхан, Увс, Говь-Алтай, Ховд, Өмнөговь аймгууд ба ОХУ-ын хил орчмын субъектуудын хооронд хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллахыг мөн дээр дурьдсан аймгуудаас тавьсан тодорхой саналуудыг анхааралдаа авч үзэхийг ОХУ-ын субъектуудад зөвлөмж болгожээ. Тухайлбал, Ховд аймаг ХАА-н техник, нефть бүтээгдэхүүн, эм, эмнэлгийн хэрэгсэл, даавуу, гутал, сүлжмэл ба оёмол эд зүйлс, хүнсний ногоо ургамлын үр импортлох, геологи, барилгын материал, хүнсний салбарт хамтарсан үйлдвэрийн газрууд байгуулах, арьс мах, загас экспортлох, Завхан аймаг өргөн



хэрэгцээний бараа, нефть бүтээгдэхүүн, ХАА-н техник, мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах техник, технологи импортлож, мах, загас экспортлох ба жуулчин солилцох, Увс аймаг бага хүчин чадлын хамтарсан мах комбинат байгуулах, хүнсний комбинатын технологийг шинэчлэх, жижиг усжуулах системүүдийг сэргээх Боршоо, Тэсийн нэвтрүүлэх боомтуудаас Давст, Тэс сумын төвүүдэд цахилган дамжуулах шугам барьж байгуулах, Тэс суманд “Шар үзүүрийн” нэвтрүүлэх боомтыг нээх, Хакас ба Тувад мах, загас экспортлох, худалдааны ярмаркууд харилцан зохион байгуулах, Улаангомд Хакас ба Тувагийн бөөний худалдааны төв байгуулах, соёл гэгээрэл, эрүүлийг хамгаалах салбарт төлөөлөгчид солилцох, жуулчны солилцоогоо өргөтгөх, нефть бүтээгдэхүүн ба үр тариа импортлох, Говь-Алтай аймаг махны хүйтэн зоорь хамтарч байгуулах, газар тариалангийн салбарт Алтайн хязгаартай мэргэжилтэн солилцох, уран сайхны чуулгууд, соёлын ажилтнууд солилцох, орос хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх, чацарганы тос ба дарс экспортлох, Өмнөговь аймаг химийн бүтээгдэхүүн, эм, эмнэлгийн хэрэгсэл, автын сэлбэг, усжуулалтын тоног төхөөрөмж, сүлжмэлийн машин, бөс даавуу импортлох, Хөвсгөл аймаг мах ба үслэг эд боловсруулах хамтарсан үйлдвэр байгуулах, жуулчин солилцох, Дорнод аймаг Дээд Ульханаас Ульханд, Соловьевскоос Чулуун Хороотод цахилгаан эрчим хүч импортлох, орос хэлний сургалттай дунд сургууль нээх, Чойбалсан хотод Оросын бараа худалдаалах бөөний худалдааны төв байгуулах, АН-3 маягийн зорчигч тээврийн нисэх онгоцууд худалдан авах буюу түрээсээр авах, ХАА-н техник импортлох гэх мэт.

Хуралдаанд оролцогчид бас Завхан аймаг ба Бүгд Найрамдах Тува Улсын хооронд хамтран ажиллах хэлэлцээр байгуулагдсан тухай мэдээлэл хүлээн авсан байна. Хуралдаанаас 2002 онд Монголын Засгийн газар Дэлхийн Банк ба олон улсын бусад байгууллагуудтай хамтран Улаанбаатарт зохион байгуулах хөрөнгө оруулагчдын олон улсын чуулгад оролцохыг Оросын сонирхогч байгууллагуудад зөвлөмж болгожээ. Ийнхүү Дэд комиссын II хуралдаан маш ажил хэрэгч, бүтээлч идэвхтэй болж манай хоёр орны бүс нутаг, хил орчмын субъектуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх эрэлт хэрэгцээ, бодит боломж нээлттэй бөгөөд өргөжин тэлэх үндэс суурьтайг олон талаар нотлон харуулснаар онцлог юм.

Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны дэд комиссын III хуралдаан 2003 оны нэгдүгээр сарын 19-20-нд ОХУ-ын Новосибирск хотод болж дэд комиссын II хуралдааны шийдвэр, зөвлөмжийн биелэлтийг дүгнэн, хамтын ажиллагааны тулгамдсан асуудал, цаашдын зорилтын тухай, Монгол Улсын Ерөнхий сайдын ОХУ-д хийх айлчлалынх нь хүрээнд Чита, Эрхүү, Кемеров мужуудад зочлуулах, тэдгээртэй

хамтран ажиллахтай холбогдсон өргөн хүрээтэй санал солилцжээ. Хуралдаанд хил залгаа орон нутаг хоорондын хамтын ажиллагааны асуудлаар Дорнод аймаг, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын төлөөлөгчид сонсгол тавьж, Сэлэнгэ аймгийн төлөөлөгч Алтанбулагийн худалдаа-эдийн засгийн чөлөөт бүсийн талаар танилцуулга мэдээлэл хийж, Новосибирскийн төлөөлөгч Бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийн талаар сонсгол хийж, саналаа танилцуулжээ.

Хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлын талаар Протокол гаргаж ОХУ-ын Үйлдвэрлэл, шинжлэх ухааны яамны тусгай хөтөлбөрийн хүрээнд хөдөөгийн хүн амыг нар, салхины эрчим хүчний төхөөрөмжийн тусламжтайгаар эрчим хүч, дулаан, халуун усаар хангах төслийг Монголын эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ОХУ-ын хэд хэдэн компаний саналыг дэмжиж, мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах, малыг эрүүлжүүлж бруцеллээ болон бусад халдварт өвчнөөс хамгаалах арга хэмжээ авах, баруун аймгуудаас ОХУ-ын ХААЯ-ны дэргэдэх мал эмнэлгийн албанд тавих, үрийн болон хүнсний улаан буудайг ОХУ-ын хөрш зэргэлдээ мужуудаас бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд бараа солилцоо болон төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр импортлох асуудлыг Монголын талын үнийн саналыг харгалзан Оросын тал нааштай шийдвэрлэж байх, хулгайлагдсан болон бэлчээрээр хил давсан малыг эрэн сурвалжлах, буцаан өгөх талаар орон нутгийн байгууллагуудаас тодорхой арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэхээр заажээ.

Тус хуралдаан зохион байгуулалт, шинэчлэлтийн чанартай зарим асуудлыг анхааран хоёр талын мал эмнэлэг, үржлийн албадын хооронд байгуулсан хэлэлцээрийг шинэчлэх, гаалийн албадын хооронд хамтран ажиллах тухай 1995 оны Протоколыг шинэчлэх, “хилийн боомт болон Монгол, Оросын хилийн хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Засгийн газар хоорондын 1994 оны Хэлэлцээрт өөрчлөлт нэмэлт оруулах шийдвэр гаргасан байна. Эдгээрээс хилийн боомтын асуудлаар хамтарсан ажлын хэсэг байгуулж асуудлыг боловсруулахдаа олон улсын автомашины “Алтанбулаг-Хиагт”-ын нэвтрүүлэх боомтын шалган нэвтрүүлэх дэглэмийг боловсронгуй болгох, “Ханх-Монд”-ын боомтыг олон улсын зэрэглэлтэй болгох асуудлуудыг тусгах нь зүйтэй гэж үзжээ.

Хил орчмын хамтын ажиллагааны хүрээнд хамтарсан үйлдвэр байгуулах, Монгол Улсын үйлдвэрүүд хагас болон анхан шатны боловсруулалт хийсэн түүхий эд, материалаар эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр хамтран ажиллах саналтай үйлдвэрүүдийг Оросын тал тодруулах, Монголын хил орчмын сум, суурин газарт ОХУ-аас хангах эрчим хүчний шугам барьж байгуулах ажилд хил орчмын

субъектуудаас хөрөнгө оруулах боломжийн тухай асуудлыг Монголын тал судалж мэдээлэх үүрэг хүлээсэн ажээ.

Хуралдааны үеэр бүс нутгийн хамтын ажиллагааны асуудлаар хоёр улсын гадаад яамдын зөвлөлдөх уулзалт болж, ийм зөвлөлдөх уулзалтыг тогтмолжуулж Дэд комиссын хуралдааны үеэр хийж байхаар тохиролцсон нь Дэд комиссын үйл ажиллагааг дэмжин идэвхжүүлэх нөлөө бүхий арга хэмжээ болов.

Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны засгийн газар хоорондын дэд комиссын 2004 оны 4 дүгээр сарын эхээр Улаанбаатарт болсон IV хуралдаан Монгол Улс ба ОХУ-ын Сибирийн бүсийн хамтын ажиллагааны асуудалд ихээхэн анхаарал тавьжээ. Чухам энд хоёр талын хамтын ажиллагааны ашиглагдаагүй үлэмж нөөц байгаа. Сүүлийн үед Монгол ба Сибирийн бүс нутгийн хооронд хамтын ажиллагаа өсч хөгжих, худалдааны эргэлт нэмэгдэх хандлагатай болж байгааг тус хуралдаан онцлон тэмдэглэсэн байна. Энэ хуралдаанд оролцсон ОХУ-ын Ерөнхийлөгчийн Сибирийн тойрогт суугаа бүрэн эрхт төлөөлөгчийн I орлогч И.Простяков өнгөрсөн онд тус бүсийн хоёр талын худалдааны эргэлт 9 хувийн өсөлттэй байсан хийгээд хоёр улсын нийт 300 сая ам.долларт хүрээд байгаа худалдааны эргэлтийн 70 илүү хувь нь Сибирийн бүсэд оногдох болсны амжилтыг бататгах ёстой гэж үзэж байгаагаа илэрхийлсэн юм. Дэд комиссын гишүүд эерэгээр бүрэлдэж буй бодит нөхцөл, хөгжлийн нааштай хандлагыг зохих ёсоор үнэлэн түүнийг бататгахад чиглэсэн хэд хэдэн чухал санаа, зорилт дэвшүүлжээ. Тухайлбал, хил орчмын районуудад улирлын шинжтэй яармагууд зохион байгуулах, Тувагийн үйлдвэрлэгчдийн оролцоотойгоор Баруун Монголд бөөний худалдааны сүлжээ бий болгох, хилийн гарам боомтуудыг тоноглох, гаалийн үзлэгийг шуурхай болгох зэргийг дурдаж болно.

Мөн Монголын нутгаас мах нийлүүлэх ажлыг сэргээж цаашид өргөтгөх, энэ талаар хоёр орны мал эмнэлэг, эдийн засгийн албадын хамтарсан ажиллагааг үргэлжлүүлэх сонирхлыг илэрхийлж байв. Монголын хөдөө аж ахуйд чийг усны нөөцийг хамгаалах технологи, үр тариа, тэжээлийн шинэ сорт, малын шинэ угсааг нэвтрүүлэх тухайд хоёр тал тохиролцжээ.

Дэд бүтцийн хүрээнд Улаанбаатар-Барнаулын агаарын шугам бий болгох төслийг авч үзэх, Тувагаас Баруун Монголд эрчим хүч дамжуулах нэмэлт шугам татах, Читийн замчдыг Монголын Дорнод нутгийн зам байгуулалт, түүний дотор Мянганы замын хэсэгт ажиллуулах, мөн Монголын баруун бүс дэх “Асгатын” мөнгөний орд газрын талаар хамтарсан боловсруулалтыг үргэлжлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах, ялангуяа олон улсын хориг цээрт хамаарах халдварт өвчний сэжиг, илрэлийг тухайд харилцан яаралтай мэдээлэл солилцож байхаар санал нэгджээ.

Ийнхүү худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн салбарт хамтран ажиллах Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын “Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны дэд комиссыг” байгуулан ажиллуулснаар хоёр улсын харилцааг нийгэм, эдийн засгийн амьдралын хамгийн өргөн хүрээнд зах зээлийн шинэ харилцаа, бодит нөхцөл, хүчин зүйлтэй нь холбон хөгжүүлэх, ялангуяа уг үйл явцад шууд оролцогч субъектуудын бие даасан идэвхи, санаачлагыг өрнүүлж, бүс нутаг хил орчмын хамтын ажиллагааг шинэ шатанд гарган байнга нөлөөлөгч чухал механизмыг бүрдүүлж чадав.

Цаашид энэ механизмыг Монгол, Оросын бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны хүрээнд боловсруулсан шийдвэрүүдийг бүрэн хэрэгжүүлэх, тэдгээрийг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулах чиглэлээр хамгийн үр ашигтай ажиллуулах нь чухал юм.

### **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

1. Протокол первого заседания Подкомиссии по региональному и приграничному сотрудничеству Российско-Монгольской Межправительственной Комиссии по торгово-экономическому и научно-техническому сотрудничеству от 10 июня 1997г. г. Улан-Удэ.
2. Протокол второго заседания Подкомиссии по региональному и приграничному сотрудничеству Российско-Монгольской Межправительственной Комиссии по торгово-экономическому и научно-техническому сотрудничеству от 20 июня 2001г. г.Улаанбаатар.
3. Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны дүнгийн тухай мэдээлэл. 2003 оны 1 дүгээр сарын 20. Новосибирск хот.
4. Оросын Холбооны Улсын субъектуудын гүйцэтгэх засаглалын байгууллага болон Монгол Улсын орон нутгийн засаг, захиргааны хоорондын хамтын ажиллагааны зарчмуудын тухай ОХУ-ын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр. 2000 оны 11 дүгээр сар.
5. Монгол, Оросын Гэрээ, хэлэлцээрүүдийн эмхтгэл /1990-2001/. УБ. 2001 он.
6. Засгийн Газрын мэдээ. 1993. №5.
7. Наука в Сибири. октябрь, 2002 г.